

COVID-19-ийн нөлөөгөөр Японд дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа байнгын оршин суугчдад зориулав

(2021 оны 4 сарын 16-ны өдрөөс хойш)

COVID-19-ийн нөлөөгөөр Японд дахин нэвтрэх зөвшөөрөл болон дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа байнгын оршин суугч дараахь аргаар Япон улсад дахин нэвтрэх боломжтой (*1) тул, оршин суугаа газрын Японы элчин сайдын яам эсвэл консулын газартай зөвлөлдөнө үү.

(1) Дахин нэвтрэх зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа бол;

Оршин суугаа газрын Японы элчин сайдын яам эсвэл консулын газарт дахин нэвтрэх зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдол бий.

[(хүчинтэй байх хугацаа дууссан өдрөөс 1 жилийн хугацаагаар сунгана.]

Хэрэв дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол, хүчинтэй байх хугацаандаа багтааж Япон руу дахин орно уу. Хэрэв сунгаж чадахгүй бол Япон руу нэвтрэх арга (2)-г ашиглана уу.

(2) Дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд, (арга (1)-г ашиглах боломжгүй тохиолдлыг оруулна.)

[Энэ нь дахин нэвтрэх зөвшөөрөл, эсвэл тусгай дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дуусах өдөр нь 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хилээр нэвтрэх хязгаарлалтыг цуцалсан өдөр (*2) хүртэлх огнооноос хойш **зургаа буюу гүүнээс сар өнгөрсөн ба Хяналтын газраас тусгайлан заасан өдөр** (*3) хүртэлх огноонд багтах гадаадын иргэнд хамаарна (*4).]

Оршин суугаа улсынхаа Японы элчин сайдын яам буюу консулын газарт хилээр нэвтрэх хязгаарлалтыг цуцалсан өдрөөс хойш зургаа буюу түүнээс дээш сар өнгөрснөөс хойш Хяналтын газраас тусгайлан заасан өдөр гэхэд “Япон улсад цагаачлагч”-н визийн мэдүүлгээ өгнө үү.

Виз гарсны дараа, Япон улсад нэвтрэн орох үедээ Японы нисэх онгоцны буудлын гааль дээр "байнгын оршин суугч"-н статусаар шинээр мэдүүлэх боломжтой.

*1 Энэ арга хэмжээнд хамрагдсан байсан ч гэсэн оршин суугаа улс, бүс нутгийн Хилээр нэвтрэх хязгаарлалт цуцлагдаагүй тохиолдолд, онцгой нөхцөл байдал үүссэн гэсэн тохиолдлыг оруулахгүйгээр, Япон руу нэвтрэхийг хориглоно.

- *2 Хилээр нэвтрэх хязгаарлалтыг цуцалсан өдөр гэж таны оршин сууж буй улс, бүс нутгийн “хилээр нэвтрүүлэхээс татгалзсан” болон “олгогдсон визийг хүчингүй болгох” арга хэмжээ цуцлагдсан өдрийг хэлнэ.
Хилээр нэвтрэх хязгаарлалтыг цуцалсан огноотой холбоотой улс, бүс нутгийн талаарх мэдээллийг Хууль зүйн яамны вэб хуудаснаас үзнэ үү.
<http://www.moj.go.jp/isa/content/930005848.pdf>
- *3 [“Хяналтын газраас тусгайлан заасан өдөр”](#) хэмээх огноог Хяналтын газрын вэбсайтад ойролцоогоор гурван сарын өмнө зарлана.
- *4 [Энд](#) дарж дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй хугацааг шалгана уу. Хилээр нэвтрэх хязгаарлалтыг цуцалсны дараа та Хяналтын газраас тусгайлан заасан өдөр хүртэл улс руу нэвтрэх боломжтой. (Дахин нэвтрэх зөвшөөрлийг **2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр** дээр дурдсанчлан сунгасан.)
- *5 (1) болон(2)-г бүрдүүлэхэд шаардлагатай бичиг баримтыг Гадаад харилцааны яамны дараахь нүүр хуудаснаас үзнэ үү.
https://www.mofa.go.jp/about/emb_cons/mofaserv.html
- *6 Хэрэв энэ арга хэмжээнд хамрагдсан хүн энэхүү арга хэмжээг ашиглалгүй, хил нэвтрэх хязгаарлалтыг цуцалсан өдрөөс хойш 6 буюу түүнээс дээш сар өнгөрснөөс хойш Хяналтын газраас тусгайлан заасан өдөр гэхэд "байнгын оршин суугч"-аас бусад оршин суух статусаар Япон улсад орсон бол, мөн хилээр нэвтрэн орсноос хойш 6 сарын хугацаанд байнгын оршин суух зөвшөөрөл авахыг хүсвэл, байнгын оршин суух зөвшөөрөл авах өргөдөл, өргөдөл ([лавлагааны маягт 1-г хавсаргав](#)), өмнөх оршин суух үнэмлэхний хуулбарыг үндэслэн шалгана (шаардлагатай бол бусад материалыг өгөх болно).
Хэрэв та Япон улсад нэвтрэн орсноос хойш 6 сарын дараа байнгын оршин суух зөвшөөрөл авах өргөдөл гаргасан бол, ердийн байнгын оршин суух зөвшөөрлийн өргөдөл болон түүнтэй адил нотлох баримт бичиг шаардагдах болно гэдгийг анхаарна уу.
Хэрэв та байнгын оршин суух зөвшөөрөл авснаар дунд болон урт хугацааны оршин суугч болсон бол байнгын оршин суух зөвшөөрлөө авсны дараа өөрийн оршин суугаа хот, дүүргийн захиргаанд оршин суух хаягаа мэдэгдэнэ үү.